

Германы алдарт халуун вино

Орц

- ¾ аяга ус
- ¾ аяга элсэн чихэр
- 1 синнамон иш
- 1 жүрж
- 10 башир цэцэг
- 750 мл улаан вино

Заавар

1. Шанаганд бэлдсэн ус, элсэн чихэр, синнамон ишээ хийж буцалгана. Буцалсаны дараа бага гал дээр тавина.
2. Жүржээ хагас болгон хувааж шүүсийг нь шахаж, усандаа хийнэ. Жүржийн хальсанд башир цэцгээ зоож мөн адил усандаа хийнэ. 30 минут бага гал дээр өтгөртөл буцалгана.
3. Улаан дарсаа хийж буцалтал биш, уур гарч эхэлтэл плиткан дээр байлгаснаар бэлэн болно.
4. Халуун усанд хийж гаргасан эсвэл уураар бүлээсгэсэн шилэн аяга эсвэл хундаганд хийж ууна. Хүйтэн аяга хагарах аюултай.

